



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
НАРИЙНТЭЭЛ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 05 өдөр

Дугаар 1102

Нарийнтээл сум

Сарчилсан төлөвлөгөө батлах тухай

Төсвийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.6 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Сумын 2023 оны төсөв батлах тухай" 2022 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр хуралдааны 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвийн сарчилсан хуваарийг 1 дүгээр хавсралтаар, Засаг даргын Тамгын газрын төсвийн сарчилсан хуваарийг 2 дугаар хавсралтаар, багуудын төсвийн сарчилсан хуваарийг 3 дугаар хавсралтаар, сумын орон нутгийн орлогыг 4 дүгээр хавсралтаар, Ерөнхий боловсролын сургууль, Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, Эрүүл мэндийн төв, Баянтээг багийн бага сургууль, Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, Хүн эмнэлэг, Соёлын төв зэрэг байгууллагуудын тогтмол зардал болон гэрээт ажилчдын цалинг 5 дугаар хавсралтаар, сум хөгжүүлэх сангийн зарцуулалтын хуваарийг 6 дугаар хавсралтаар, орон нутгийн хөгжлийн сангийн сарчилсан хуваарийг 7 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дээрх байгууллагуудын төсвийг батлагдсан төсөвт багтаан сарчилсан хуваарийн дагуу зарцуулж байгаад хяналт тавьж ажиллахыг Санхүү албаны дарга (П.Сольтогтох)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б. СУГАР



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
НАРИЙНТЭЭЛ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/03

Нарийнтээл сум

Сургалт зохион байгуулах зөвшөөрөл  
олгох тухай

Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайдын 2018 оны 04 дүгээр сарын 03-ны А/168 дугаар тушаалаар батлагдсан "Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр сургалт явуулах журам"-ыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэдэд бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалт болон бусад сургалтуудыг орон нутгийн хэмжээнд 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн 2 жилийн хугацаатай зохион байгуулах зөвшөөрлийг Насан туршийн боловсролын нэгжийн багшид олгосугай.
2. Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалт болон бусад сургалтуудыг зохих заавар журмын дагуу зохион байгуулан, холбогдох байгууллагуудад мэдээ тайланг хугацаанд нь хүргүүлж байхыг Насан туршийн боловсролын нэгжийн багш (Т.Батдулам)-д үүрэг болгосугай.
3. Энэ захирамж гарсантай холбогдуулан 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/167 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Б.СУГАР



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
НАРИЙНТЭЭЛ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/01

Нарийнтээл сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4, 34 дүгээр зүйл, аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн "Цэргийн бүртгэл явуулах тухай" А/01 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2023 оны цэргийн бүртгэлийг явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Ичинноров (Тамгын газрын дарга)

Гишүүдэд: Б.Ариунаа (Архив, бичиг хэргийн эрхлэгч)

А.Лхагвадолгор (Улсын бүртгэгч)

О.Цэрэннадмид (1 дүгээр багийн Засаг дарга)

Б.Базарсад (2 дугаар багийн Засаг дарга)

О.Мягмар (3 дугаар багийн Засаг дарга)

Ц.Мөнх-Эрдэнэ (4 дүгээр багийн Засаг дарга)

Т.Батдулам (Насан туршийн боловсролын нэгжийн арга зүйч)

Цэргийн тоо бүртгэлийг: Цагаан Овоо баг: 2023 оны 01 дүгээр сарын 10-11

Шарга баг: 2023 оны 01 дүгээр сарын 12

Өндөр хөмөг баг: 2023 оны 01 дүгээр сарын 13

Баянтээг баг: 2023 оны 01 дүгээр сарын 16

өдрүүдэд тус тус явуулсугай.

2.Ээлжит цэргийн тоо бүртгэлийн бэлтгэлийг хангаж, 18-55 насны эрчүүд, тусгай мэргэжлийн эмэгтэйчүүдийг бүрэн хамруулан, цэргийн тоо бүртгэлийг чанартай, үнэн зөв явуулж, дүн мэдээг хугацаанд нь аймгийн Цэргийн штаб-т хүргэхийг ажлын хэсэг (Б.Ичинноров)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР

G22311007

D.My:Doc.A4Zahiramj /ZD/



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
НАРИЙНТЭЭЛ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/04

Нарийнтээл сум

┌ Албан тушаалын тодорхойлолт батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны "Зөвшөөрөл олгох тухай" 42 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Соёлын төвийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан албан тушаалын тодорхойлолтыг 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн мөрдөж үр дүнг хариуцан ажиллахыг Соёлын төвийн даргад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.СУГАР





ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
НАРИЙНТЭЭЛ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/05

Нарийнтээл сум

Тооллогын комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Нийгмийн даатгалын тухай хуулийн 33 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тэтгэврийн хувийн хэргийг тоолох комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Н.Нямсүрэн (Нийгмийн даатгалын ажилтан)

Гишүүд: А.Лхагвадолгор (Улсын бүртгэгч)

Ч.Номин-Эрдэнэ (Халамжийн ажилтан)

Ж.Адьяадорж (Газрын даамал)

О.Пүрэвдулам (Татварын байцаагч)

2.Тэтгэврийн хувийн хэргийн тооллогыг чанартай зохион байгуулж ажиллахыг тооллогын комиссын дарга (Н.Нямсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР

№ 622311015

D.My:Doc.A4Zahiramj /ZD/



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
НАРИЙНТЭЭЛ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/06

Нарийнтээл сум

Хөрөнгө зарцуулах тухай

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, 17.2.6 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Сумын 2023 оны төсөв батлах тухай" 2022 оны 12 дугаар 17-ны өдрийн 11 дүгээр хуралдааны 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын нутаг дэвсгэрт хууль бусаар алт олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг таслан зогсоох зорилгоор хийгдэх эргүүл, хяналт, шалгалт, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрүүлэхэд чиглэгдсэн ажлыг тухай бүр нь зохион байгуулж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Г.Наранбаатар), хэсгийн төлөөлөгч (н.Түмэнжаргал) нарт үүрэг болгосугай.

2.Дээрх зардалд зарцуулах хөрөнгийг сар бүр тооцож анхан шатны баримтад тулгуурлан байгаль хамгаалах сангаас зарцуулж байхыг санхүү албаны дарга (П.Сольтогтох)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
НАРИЙНТЭЭЛ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/07

Нарийнтээл сум

Албан тушаалын тодорхойлолт батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны "Зөвшөөрөл олгох тухай" 42 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Соёлын төвийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан албан тушаалын тодорхойлолтыг 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн мөрдөж үр дүнг хариуцан ажиллахыг Соёлын төвийн даргад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.СУГАР



622311019

D.My:Doc.A4Zahiramj /ZD/



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
НАРИЙНТЭЭЛ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/108

Нарийнтээл сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн "Босго үнэ шинэчлэн батлах тухай" 124 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Малын эрүүл мэндийн үйлчилгээнд зарцуулах" ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Бямбадолгор (Мал эмнэлгийн тасгийн дарга)

Гишүүд: Б.Шинэбаатар (Мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн)

П.Төмөртоогоо (Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч)

Д.Энхжин (Газар тариалан хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: С.Баасандулам (Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн)

2. Бараа худалдан авахдаа худалдан авах ажиллагааны журмын дагуу ажиллаж чанарын шаардлага хангасан бараа нийлүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Д.Бямбадолгор)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР





ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
НАРИЙНТЭЭЛ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 01/09

Нарийнтээл сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 86 дугаар тушаалын хавсралт "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 8.5, 8.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сан дахь данснаас гүйлгээ хийх төлбөрийн хүсэлтийн баримтад 1 дүгээр гарын үсгийг Засаг даргын Тамгын газрын дарга, 2 дугаар гарын үсгийг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч нарт зурахыг зөвшөөрсүгэй.

2.Орон нутгийн хөгжлийн санг журмын дагуу захиран зарцуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Ичинноров)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР

622311025

D.My:Doc.A4Zahiramj /ZD/



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
НАРИЙНТЭЭЛ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/10.

Нарийнтээл сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус суманд цас их орж зудын нөхцөл байдал үүсч малчдын нөхцөл хүндэрсэн тул малын тэжээлийн дэмжлэг болгон 6.750.000 (зургаан сая долоон зуун тавин) мянган төгрөгийг зарцуулж тооцоог хавсралтаар баталсугай.

2.Дээрх 6.750.000 төгрөгийг эрсдлийн сангаас гаргахыг Төсвийн ерөнхий нягтлан бодогч (П.Сольтогтох)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР

№ 622311027

D.My:Doc.A4Zahiramj /ZD/



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
НАРИЙНТЭЭЛ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/11

Нарийнтээл сум

Шууд гэрээ байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 36 дугаар зүйлийн 36.1.4 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Малын эрүүл мэндийн үйлчилгээнд зарцуулах" тендерт нэг ч үнийн санал ирээгүй тул шууд худалдан авалтаар гэрээг байгуулсугай.

2. Дээрх тендерт шууд гэрээ байгуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Ичинноров)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НАРИЙНТЭЭЛ СУМЫН БАРАА, АЖИЛ,  
ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ  
СОНГОН ШАЛГАРУУЛСАН АЖЛЫН ХЭСГИЙН  
ЗӨВЛӨМЖ**

2023.01.23

Дугаар 01

"Цагаан-овоо"

**ЗАСАГ ДАРГА Б.СУГАР ТАНАА**

Үнэлгээний дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх  
тухай



"Малын эрүүл мэндийн үйлчилгээнд зарцуулах" саналыг 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 10.00 цаг хүртэл саналыг хүлээн авч, 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 11 цаг 50 минутанд нээх урилга хүргүүлсэн боловч нэг ч үнийн санал ирүүлээгүй байна.

Уг тендерийг уламжлалт хэлбэрээр зарласан.

Ажлын хэсгийн саналаар "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 34-р зүйлд заасны дагуу шууд гэрээ байгуулахаар шийдвэрлэсэн.

Ажлын хэсгийн гишүүдийн 100 хувийн саналаар шууд байгуулах тухай зөвлөмжийг хүргүүлж байна.

АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ  
НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА

 Д.БЯМБАДОЛГОР  
 С.БААСАНДУЛАМ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
НАРИЙНТЭЭЛ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/12

Нарийнтээл сум

Шинээр газар эзэмших тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.18, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 30 дугаар зүйлийн 30.1 дэхь заалт, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 11/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. ТААЦ ПАУЭР ХХК-ний газар эзэмших хүсэлтийн дагуу 2 дугаар багийн нутаг дэвсгэрт Уужим буланд 24.4402га газрыг "Усан цахилгаан станцын" зориулалтаар 60 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигч аж ахуй нэгжид газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгэхийг Газрын даамал (Ж.Адъяадорж)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР

№ 622311029

D.My:Doc.A4Zahiramj /ZD/